



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 06 сарын 28 өдөр

Дугаар А/360

Эрдэнэт

Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5/д/, 29.2, Монгол улсын “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай” хуулийн 37 дугаар зүйлийн 2.1, Засгийн газрын 2016 оны 200 дугаар тогтоол, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд нарын 2014 оны А/05, А/14, 16 хамтарсан тушаал, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн ээлжит III хуралдааны 01 дүгээр тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн VI хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орхон аймгийн харъяат 0-16 насны амьдарч байгаа хүүхдүүдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тодорхойлох, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулах асуудлаар дүгнэлт гаргах, зуучлах, хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагааг зохион байгуулдаг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагааны зардал 10716000 /Арван сая долоон зуун арван зургаан мянган/ төгрөгийг “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагааны зардлаас” гаргахыг Санхүү төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

2.Батлагдсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулан, үр дүнг тайлагнаж ажиллахыг Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс /н.Бумансор/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.БАТЛУТ

Аймгийн Засаг даргын 2017 оны 6
дугаар сарын 28 ны өдрийн 486 дугаар
захирамжийн хавсралт

**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД,
БОЛОВСРОЛ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЛБАР
КОМИССЫН ЗАРДЛЫН ТООЦОО**

№	Үйл ажиллагааны чиглэл	1 сард олгох урамшуулал	Эхний хагас жилд олгох	Хоёрдугаар хагас жил	Нийт дүн
1	Урамшууллын зардал /гишүүний тоо 8/	893040	4911720	4911720	9823440
2	Бичиг хэрэгсэл, бичиг баримт олшруулах, сургалт, мэдээлэл өгөх	Улиралд 250000	500000	392560	892560
Нийт дүн				10716000	